



НИЙСЛЭЛИЙН  
НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 02 сарын 12 өдөр

Дугаар А/08

Улаанбаатар хот

Шуурхай зөвлөгөөний дэг  
батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, газрын хөдөлмөрийн дотоод журмын 2 дугаар зүйлийн 2.1.11 дэх заалтын үндэслэн ТУШААХ НЬ:

1. Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газрын шуурхай зөвлөгөөний дэгийг 1 дүгээр хавсралтаар, шуурхайд суух албан хаагчдын нэрсийг 2 дугаар хавсралтаар тус тус баталж, 2018 оны 02 сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

2. Шуурхай зөвлөгөөний дэгийн биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга /С.Доржсүрэн/, Дотоод хяналт хариуцсан ажилтан /Ч.Шинэчимэг/, Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга /Б.Орхонбайгаль/ нарт тус тус үүрэг болгосугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан газрын даргын 2013 оны А/52 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Х.ӨРДЭНЭБИЛЭГ

1150500015